

1. АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ-ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГО

Зорилт 6.4. Уур амьсгалын өөрчлөлт

Арга хэмжээний дугаар 6.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.
Хэрэгжих хугацаа 2021-2025

Хэрэгжилт: Засгийн газрын хэрэгжүүжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газраас Отгон сумын цаг уурын өртөөнд цаг уурынавтомат станцын иж бүрдэл, тоног төхөөрөмжийг хүлээн авч тус өртөөнд суурилуулан 2024 оны 10 дугаар сараасхэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажилласан.

2.АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Зорилт 5.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.

Арга хэмжээний дугаар 5.4.1.1. Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

Хэрэгжилт: Завхан бороо” Экспедиц энэ сард Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг “Завхан бороо-1” экспедиц VII дугаар сарын 3, 3-4, 20, 21, 22-ны өдрүүдэд JFJ-3а борооны пуужингаар нийт 2 удаагийн үйл ажиллагаа явуулсан. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд JFJ-3а борооны пуужин 17 ш-ийг зарцуулж нийт 51 гр урвалж зарцуулсан байна.Ажиллагаа-1.Хур тунадасны мэдээллээр Улиастай, Баянхайрхан 12,0мм, Яруу 10,0мм, Баянтэс 9,0мм, Сонгино 7,0мм, Цагаанхайрхан 6,0мм, Цэцэн-Уул 5,3мм, Их-Уул, Түдэвтэй, Тэлмэн, Эрдэнэхайрхан 5,0мм, Шилүүстэй 3,3мм, Нөмрөг, Тэс 3,0мм, Сантмаргаз 2,3мм, Отгон, Алдархаан, Идэр, Цагаанчулуут 1,0мм, Завханмандал 0,7мм, Тосонцэнгэл 0,1мм, Ургамал 0,0мм, хур тунадас орсон нийт 97,7мм тунадас орсон. бусад сумдаар хур тунадас ороогүй.Үйл ажиллагааны тухай мэдээллийг ЦУОШГ-т хүргүүлсэн. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулахад нийт 1062 км маршрут зам туулсан байна.Ажиллагаа-2.Хур тунадасны мэдээллээр Эрдэнэхайрхан 26,0мм, Яруу 21,0мм, Цэцэн-Уул 13,0мм,Түдэвтэй 11,0мм, Дөрвөлжин 9,0мм, Алдархаан, Нөмрөг 8,0мм, Шилүүстэй 7,0мм, Цагаанхайрхан, Улиастай 6,0мм, Сантмаргаз 5,0мм, Идэр,Тэлмэн 4,0мм, Отгон, Сонгино,Завханмандал 2,0мм, Тэс 0,8мм, Баянтэс 0,6мм, Тосонцэнгэл 0,3мм, Их-Уул 0,0мм хур тунадас орсон нийт 135,7мм тунадас орсон. бусад сумдаар хур тунадас ороогүй.

Үйл ажиллагааны тухай мэдээллийг ЦУОШГ-т хүргүүлсэн. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг явуулахад нийт 1600 км маршрут зам туулсан байна.

Зарцуулсан хөрөнгийн хэмжээ,

эх үүсвэр (сая төгрөг) Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаанд JFJ-3а борооны пуужин 17 ш-ийг зарцуулж нийт 51 гр урвалж зарцуулсан байна.Нийт 5'975'500 төг зарцуулсан.

Хүрсэн түвшин Аймгийн нутаг дэвсгэрт цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны явуулах бэлтгэл бэлэн байдлыг удирдлагын зүгээс шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллаж ирлээ. Дээрх хугацаанд цаг агаарын хуурайшилттай нөхцөл бүрдсэн сумдын дарга нарын хүсэлт, хэрэгцээ шаардлагын ханган бүс нутгуудад ажиллаж нийт нутгийн 75% зуншлага хэвийн сайн, 25 % дунд гандуу байна.

Зорилт 5.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.

Арга хэмжээний дугаар 5.4.1.2. Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлнэ

Хэрэгжилт: Аймгийн 24 сумдын нутгаар хагас хоног, нэг хоног, 5, 7 хоног, сар, улиралын төлөвүүд өдөр бүр, 1 хоног, 7 хоногийн тойм, хуурайшилт гэх мэт мэдээг тухай бүр гаргаж, нийт 455 мэдээг олон нийтийн сүлжээнд тавьж, ард иргэдэд 100 хувь хүргэж үйлчилсэн байна. Мөн Цаг агаарын аюулт үзэгдлийн нөхцөл бүрдсэн үед давхардсан тоогоор АНХААРУУЛГА 67, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ (цочир хүйтрэлт) 1 удаа зохиож, Завхан аймгийн нэгдсэн 3 төрлийн группэд болон “Завхан Ус цаг агаар, орчны мэдээ мэдээлэл” цахим хуудсаар, 24 сумдын салбар нэгжээр дамжуулан сумдын фэйсбүүк хаягаар төрийн болон ААНБ, ард иргэдэд өдөр бүр шинэчлэн хүргэж үйлчилсэн. Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед III улирлын байдлаар багц мессежээр 24 сумдын малчид ард иргэдийн гар утсанд 3 удаагийн давталттайгаар давхардсан тоогоор 35'533 хүнд АНХААРУУЛГА, СЭРЭМЖЛҮҮЛЭГ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ мэдээг шуурхай хүргэж ажилласан. Цаг агаарын мэдээний илрүүлэлт 100%, таарч 84%, онч 85.7%-тай байна. Хэрэгжилт 100 хувь

Зорилт 5.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.

Хэрэгжилт: Засгийн газрын хэрэгжүүжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газраас Отгон сумын цаг уурын өртөөнд 100 сая төгрөгний цаг уурын автомат станцын иж бүрдэл, тоног төхөөрөмжийг хүлээн авч тус өртөөнд суурилуулан 2024 оны 10 дугаар сараас хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажилласан.